



BE ALWAYS CONNECTED WITH
YOUR LAWYER

Address: Ulaanbaatar, Chingeltei district, 3th khoroo,
Pearl tower, A block-1201; Tel.: 77041414;
Email: contact@akp.mn

LEGAL NEWSLETTER

2024 он 03-р сар №43

Нэг. Батлагдсан УИХ-ын тогтоол

➤ **2024 оны 03-р сарын 15-ны өдрийн №19 тогтоол**

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2024 оны 04-р сарын 30-ны өдрөөс эхлэхээр товлон зарласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 10-р сарын 11-ний өдөр байхаар тогтоосон

➤ **2024 оны 03-р сарын 15-ны өдрийн №20 тогтоол**

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг хэрэглэхээр болсон.

Хоёр. Батлагдсан Засгийн газрын тогтоол

➤ **2024 оны 03-р сарын 6-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №90**

“Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай”

Тус Зөвлөлийг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргалах бөгөөд бүрэлдэхүүнд нь 7 гишүүн, 1 нарийн бичиг байхаар тогтоосон.

➤ **2024 оны 03-р сарын 6-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №91**

“Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсан.

➤ **2024 оны 03-р сарын 6-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №100**

“Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам”

Эрүүл мэндийн мэдээллийг “Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны систем” (цаашид “мэдээлэл солилцооны систем” гэх)-ээр дамжуулан солилцоно. Энэ систем нь төрийн мэдээлэл солилцооны үндсэн (ХУР) системийн бүрэлдэхүүн хэсэг байна. Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага (цаашид “мэдээлэл хариуцагч” гэх) болон нийлүүлэгч байгууллага дагаж мөрдөнө.

➤ **2024 оны 03-р сарын 20-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №119**

“Хэлэлцээр батлах тухай”

Улаанбаатар хотноо 2024.01.23-ны өдөр гарын үсэг зурсан “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсан.

➤ **2024 оны 03-р сарын 20-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №120**

“Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай”

- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.
- Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 650,000 (зургаан зуун тавин мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 540,000 (таван зуун дөчин мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

➤ **2024 оны 03-р сарын 20-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №122**

“Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 375,000 төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 302,500 төгрөгөөр тус тус тогтоосон.

➤ **2024 оны 03-р сарын 27-ны өдрийн Засгийн Газрын тогтоол №128**

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг баталсан.

Гурав.Хорооны тогтоол

➤ **2024 оны 03-р сарын 19-ний өдрийн Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны тогтоол №23**

“Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг баталсан.

*** Уг Хууль, эрх зүйн мэдээлэл нь албан ёсны хууль зүйн зөвлөгөөнд хамаарахгүй бөгөөд зөвхөн нийтийн мэдээлэл хүргүүлэх зорилготой болно

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower A блок 1201 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680